



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/36

Батширээт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол цэргийн өдөр" орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдааны шагналын зардалд 280,000 (хоёр зуун наян мянган) төгрөг, медаль өргөмжлөлийн зардалд 56,000 (тавин зургаан мянган) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501071